



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/500

Арвайхээр

Коронавируст (Ковид-19) цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Засгийн газрын 2020 оны "Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах арга хэмжээний тухай" 78 дугаар тогтоолын 10 дахь хэсэг, 2008 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан "Улсын Онцгой комиссын ажиллах журам"-ын 3 дахь хэсэг, Улсын Онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн "Зорчигч тээврийн хэрэгслийн гарах хөдөлгөөн, бүх шатны боловсролын байгууллагын хичээл, сургалт, үзвэр үйлчилгээ, цахим болон хүүхдийн тоглоомын төвүүдийн үйл ажиллагааг түр зогсоох тухай" 12 дугаар тогтоол, Аймгийн Онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 14 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бүх шатны боловсролын байгууллага, сургалтын төвийн үйл ажиллагааг 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 14-ний өдрийг хүртэлх хугацаанд түр зогсоохыг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газар (Ж.Пүрэвсүрэн)-т даалгасугай.

2. Үзвэр үйлчилгээний байгууллагууд болон олон нийтийг хамарсан хурал цуглаан, сургалт, спортын тэмцээн уралдаан, соёл урлаг, сүм хийд, кино театр, цахим болон бага насны хүүхдийн төрөл бүрийн тоглоомын газрын үйл ажиллагааг түр зогсоохыг аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Цар тахлын онцгой нөхцөл байдлын үед бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгах, нийлүүлэлт, борлуулалтын нөхцөл байдалд хяналт тавих, үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол үүсгэхээс урьдчилан сэргийлж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр)-т тус тус даалгасугай.

4. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 14-ний өдөр хүртэлх хугацаанд архи, согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэхийг хориглосугай.

5. Худалдаа, үйлчилгээний байгууллагууд дотоод журмыгаа хүрээнд ажлын тусгай горимд шилжиж ажиллахыг аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлагуудад чиглэл болгосугай.

6. Халдварын сэжигтэй тохиолдлыг тусгаарлах орыг шат дараатай төлөвлөн бэлтгэж, голомтод ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтнийг томилж, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодисын нөөцийг бүрдүүлж, бэлэн байдлыг хангах, сэжигтэй тохиолдлын хавьтлуудыг тусгаарлан ажиглалтад авах байрыг эмнэлгээс тусад нь бэлтгэх, хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээллийг аймгийн Онцгой комисст (Uv.ontsgoi.komiss@gmail.com) 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 08:00 цагаас өмнө ирүүлэхийг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

011101107


2.

7. Аж ахуйн нэгж, байгууллага, худалдааны төвүүдэд “Маскаа зүүцгээе-Гараа угаая” 2 дахь аяны хэрэгжилтийг хангуулж ариутгал, халдваргүйтгэлийг эрчимжүүлж, хяналт тавьж ажиллахыг нийт байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

8. Энэ захирамжийн 1, 2, 3, 4 дэх заалтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гарсан зөрчлийг тухай бүр арилгаж холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн)-т тус тус үүрэг болгосугай.

9. Коронавируст (Ковид-19) цар тахлын халдвар томуу, томуу төст өвчний өвчлөл, тархалт урьдчилан сэргийлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний талаарх бодит мэдээллийг иргэдэд нэгдсэн байдлаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол хүргэж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шиваанүрдэв)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ